

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/04/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Ц.Хосжаргал Утас:260512 Цахим хаяг: Khosjargalts@audit.gov.mn Ахлах аудитор: В.Эрдэнэцогт Утас: 262071 Цахим хаяг: Erdenetsogv@audit.gov.mn Аудитор: С.Отгонхорлоо Утас:262071 Цахим хаяг: Otgonkhorloos@audit.gov.mn Аудитор: М.Пагамдулам Утас:262071 Цахим хаяг: Pagamdulamm@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ З.ЭНХБОЛД ТАНАА

2024.03.25 № 07/822
танай _____-ны № _____-г

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 274.0 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- ХЭДС-ийн авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 20,837.7 сая төгрөг;
- Банк бус санхүүгийн байгууллагад байршуулсан 1,002.0 сая төгрөгийн эх үүсвэрийн финтек/аппликешны зээлийг ашигласнаар хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн, шинээр ажлын байр бий болсон талаар тайлан, дүгнэлт гаргаагүй;
- Санхүүгийн дэмжлэг байршуулсан 36.2 сая төгрөгийн эх үүсвэрт хүү төлсөн;
- Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас хуваарилсан санхүүгийн дэмжлэгийн хүүгүй зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй, дотоод хяналт сул

зэрэг зөрчил нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, Төсвийн тухай хуулийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21, 6 дугаар зүйлийн 6.4, 6.4.8, Засгийн газрын

Z:\Yawsan_Bichig\2024\0325 SNAG-29.Docx

0001351860

2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам-ын 6.4-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх” арга хэмжээний эх үүсвэрээс Засгийн газрын 2023 оны 111 дүгээр тогтоолоор Батлан хамгаалах яам хэрэгжүүлэх “Оюутан цэрэг”-ийн үйл ажиллагаанд 2,537.3 сая төгрөгийг зарцуулах эрхийг шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол, Засгийн газрын 99 дүгээр тогтоолыг үндэслэн тайлант онд гадаадын 197 иргэний ажлын байрны төлбөрөөс 50.0 хувийн хөнгөлөлтөд 712.5 сая төгрөг, мөн нутаг буцсан 825 иргэний ажлын байрны төлбөрийг 100.0 хувь буцаан олголтод 2,510.1 сая төгрөгийг тус тус зарцуулж, Засгийн газрын 2023 оны 19 дүгээр тогтоолоор 36 аж ахуйн нэгж байгууллагын 5673 гадаад иргэнийг төлбөрөөс 100.0 хувь чөлөөлсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тайлант онд 25 зорилтын 98 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 83.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	183,834,931.6	243,587,818.0
33	АВЛАГА	183,833,771.6	243,587,818.0
35	БАРАА МАТЕРИАЛ	1,160.0	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	183,834,931.6	243,587,818.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	30,840,995.8	22,871,610.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,147,548.0	20,147,446.2
41300	Өглөг	24,651.0	45,346.0
41400	Урьдчилж орсон орлого	19,122,897.0	20,102,100.2
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,693,447.8	2,724,164.1
42200	Урт хугацаат зээл	11,693,447.8	2,724,164.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	152,993,935.8	220,716,207.7
51	Засгийн газрын хувь оролцоо	152,993,935.8	220,716,207.7
51200	Хуримтлагдсан үр дүн	152,993,935.8	220,716,207.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	183,834,931.6	243,587,818.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	49,522,789.5	95,881,730.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	49,187,464.5	93,819,305.8
120	Нийтлэг татварын бус орлого	49,187,464.5	93,819,305.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	335,325.0	2,062,425.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	25,062,391.0	28,086,032.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,062,391.0	28,086,032.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	360,488.5	4,585,141.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	185,630.5	4,554,941.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	174,858.0	30,199.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,701,902.5	23,500,891.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	24,460,398.4	67,795,698.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,086,260.8	76,508.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	22,374,137.6	67,719,189.9

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	112,925,605.4	171,640,248.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	97,017,712.5	133,331,340.8
120	Нийтлэг татварын бус орлого	97,017,712.5	133,331,340.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,907,892.9	38,308,908.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	92,925,605.4	171,636,948.8

21	УРСГАЛ ЗАРДАЛ	92,925,605.4	171,636,948.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	299,566.7	4,620,327.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	124,708.7	4,585,127.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	174,858.0	35,199.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,626,038.6	167,016,621.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	20,000,000.0	3,300.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	3,300.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	3,300.0
2200	Дотоод эх үүсвэрээр	-	3,300.0
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(3,300.0)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(20,000,000.0)	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	20,000,000.0	-
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	130,652,194.9	-	130,652,194.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(32,396.7)	-	(32,396.7)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	130,619,798.2	-	130,619,798.2
9	Тайлант үеийн үр дүн	22,374,137.6	-	22,374,137.6
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	152,993,935.8	-	152,993,935.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,082.0	-	3,082.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	152,997,017.8	-	152,997,017.8
19	Тайлант үеийн үр дүн	67,719,189.9	-	67,719,189.9
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	220,716,207.7	-	220,716,207.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	92,876,641,900.00	60,990,250,532.68	31,886,391,367.32	65.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	87,876,641,900.00	60,990,250,532.68	26,886,391,367.32	69.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,082,226,000.00	4,574,788,212.82	2,507,437,787.18	64.6

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,082,226,000.00	4,574,788,212.82	2,507,437,787.18	64.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,082,226,000.00	4,574,788,212.82	2,507,437,787.18	64.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,794,415,900.00	56,415,462,319.86	24,378,953,580.14	69.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	80,794,415,900.00	56,415,462,319.86	24,378,953,580.14	69.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	80,794,415,900.00	56,415,462,319.86	24,378,953,580.14	69.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	5,000,000,000.00	-	5,000,000,000.00	0.0
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	5,000,000,000.00	-	5,000,000,000.00	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	92,876,641,900.00	171,339,243,799.70	(78,462,601,899.70)	184.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,500,000,000.00	1,852,937,401.00	647,062,599.00	74.1
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,500,000,000.00	1,852,937,401.00	647,062,599.00	74.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	82,376,641,900.00	133,300,011,711.63	(50,923,369,811.63)	161.8
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,056,132,600.00	79,548,352,774.69	(51,492,220,174.69)	283.5
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,436,950,000.00	6,951,058,505.99	(3,514,108,505.99)	202.2
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	45,883,559,300.00	46,800,600,430.95	(917,041,130.95)	102.0
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	5,000,000,000.00	-	5,000,000,000.00	0.0
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	8,000,000,000.00	36,186,294,687.07	(28,186,294,687.07)	452.3
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	8,000,000,000.00	36,186,294,687.07	(28,186,294,687.07)	452.3
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	266,273,634.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	266,273,634.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	48,838,969.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	13,639,622.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	13,639,622.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	35,199,347.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	30,199,347.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	217,434,665.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	36,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	36,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	181,434,665.00

213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	181,434,665.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	266,273,634.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	266,273,634.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	232,848,634.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	33,425,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 34 байгууллагын тайлангууд нэгтгэгдсэнээс шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд 31 санал дүгнэлт өгч, 3 байгууллага, сангийн санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Өөрчлөлтгүй 22, Хязгаарлалттай 9 дүгнэлтийг өглөө.

Төвлөрүүлэн захирагч/ЗГТС/

Аудитаар нийт 37,579.8 сая төгрөгийн 10 зөрчил илэрснээс 36.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,179.4 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 20,858.2 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч, 15,506.0 сая төгрөгийн зөрчилд 2 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

Залруулсан алдаа:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангаагүй дараах 5 алдааг залруулсан. Үүнд:

- Орлого үр дүнгийн тайланд зээлийн эргэн төлөлтийг 29.4 сая төгрөгөөр бууруулж буруу тайлагнасан;
- Орлого үр дүнгийн тайланд төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх орлогыг 3.0 сая төгрөгийг бууруулж буруу тайлагнасан;
- Орон нутгийн байгууллагуудын мөнгөн гүйлгээний тайланд орлого, зарлагын устгах бичилт 132.5 сая төгрөгөөр илүү хийсэн;
- Мөнгөн гүйлгээний тайланд орлого, зарлагын устгалтыг 95.0 сая төгрөгөөр илүү хийсэн;
- Орон нутаг дахь ХЭДС-ийн өмнөх онд төвлөрүүлсэн татаас шилжүүлгийн авлага 1,059.3 сая төгрөгийг орлогоор бүртгэж буруу тайлагнасан;

Төлбөрийн акт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас иргэдэд хүүгүй олгох 1,002.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг "Энт кредит" ББСБ-тай байгуулсан гэрээний дагуу "Финтек"/Аппликешны зээл/ ашиглан цахим хэлбэрээр олгох үйлчилгээний хүүд жилийн 18.0 хувиар тооцож, 297.8 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 36.2 сая төгрөгийн хүүгийн зардалд зарцуулж, сангийн хөрөнгийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

Албан шаардлага

1. ХНХС-ын 2022 оны А/178 дугаар тушаалаар "Финтек" /Аппликешны зээл/ богино хугацааны эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүгийн дэмжлэг олгох санхүүгийн байгууллага сонгон шалгаруулах чиглэл өгсний дагуу шалгаруулалт явуулж, Энт кредит ББСБ ХХК-тай 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр ХХҮЕГ/24 тоот гэрээ байгуулж, 1,002.0 сая төгрөгийн эх үүсвэрийг 12 сарын хугацаатай, хүүгүй байршуулсан байна. Уг гэрээний зорилго нь "Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох, хөдөлмөр эрхлэгч иргэн, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид богино хугацааны эргэлтийн хөрөнгийн санхүүгийн дэмжлэгийг шинэ технологи ашиглан цахим хэлбэрээр дамжуулан олгох" бөгөөд тайлант онд давхардсан тоогоор 6812 иргэнд зээл олгосон байна. Энэхүү "Финтек /Аппликешны зээл/-ийг ашигласнаар хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн, шинээр ажлын байр бий болсон талаар тайлан, дүгнэлт хийгээгүй, хяналт хэрэгжүүлээгүй, үр дүнг тооцоогүй, дотоод хяналт сул байгаагаас төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.4-т "Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан улирал тутам нийт зээлдэгчийг хамруулан жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт хийж, дүн мэдээг тухай бүр хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дүн мэдээг нэгтгэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.", 2023 оны 06-р сарын 13-ны өдрийн ХХҮЕГ/24 тоот гэрээний 3.5-д " Богино хугацааны эргэлтийн хөрөнгийн санхүүгийн дэмжлэгийн эх үүсвэрийн санхүүжилт, түүний зарцуулалт, олголт, эргэн төлөлттэй холбоотой эх үүсвэрийн ашиглалтад жилийн эцсийн байдлаар дотоод аудит хийлгэж, дүнг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ", 5.1-д " Зээл олгох үйл ажиллагаа, зээлийн эх үүсвэрийн ашиглалт, эргэн төлөлт, гэрээний биелэлтийг талууд хагас жил тутамд дүгнэнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн дэмжлэгийн эх үүсвэрийн ашиглалтын үр дүнг тооцоогүй, хяналт хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

2. Тайлант оны 3 дугаар сард салбарын хууль тогтоомжийн хэлэлцүүлэг болон өмнөх оны ажил дүгнэх тайлангийн хурлыг зохион байгуулахад 48.1 сая төгрөг, 12 дугаар сард харьяа аймаг дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний газар, хэлтийн дарга нартай хэлэлцүүлэг зохион байгуулахад 23.8 сая төгрөг, жилийн эцсийн тайлангийн хурал зохион байгуулахад 12.5 сая төгрөг, холбогдох хуулийн хэлэлцүүлгийг Туушин зочид буудалд зохион байгуулж, хоол хүнсний зардалд 30.0 сая төгрөг, нийт 114.4 сая төгрөгийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:... 15.2.3.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлангийн хурал, хэлэлцүүлэг зохион байгуулахад төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

3. ХНХС-ын 2023 оны А/161 дугаар тушаалаар ХНХЯ-ны харьяа БНСУ дахь Хөдөлмөр нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үйл ажиллагаатай танилцах ажлаар УИХ-ын 7 гишүүнд 31.0 сая төгрөг, мөн ХНХС-ын 2023 оны А/07 дугаар тушаалаар төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийхээр ХНХЯ-ны 3 албан хаагчид 21.5 сая төгрөг, ХНХС-ын 2023 оны А/142 дугаар тушаалаар тус төвийн даргын ажлыг хүлээлцэхээр ХНХЯ-ны 2 ажилтанд 10.4 сая төгрөг, нийт 63.0 сая төгрөгийн гадаад томилолт олгож, зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан

төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно" гэсэн заалттай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн харьяа байгууллагуудад 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 15,276.4 сая төгрөгийн 86 алдаа, зөрчил илэрснээс 6,593.0 сая төгрөгийн 34 алдааг залруулж, 17.0 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 3,580.0 сая төгрөгийн зөрчилд 21 албан шаардлага, 5,086.3 сая төгрөгийн зөрчилд 46 зөвлөмж өгч, мөн нийцлийн асуудлаар 8,384.0 сая төгрөгийн 7 албан шаардлага, 442.8 сая төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлсэн ба төсвийн төвлөрүүлэн захирагчаас харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх дотоод аудитын үр нөлөө хангалтгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх; ..." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа сангуудын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх дотоод аудитын үр нөлөөгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэгийн эх үүсвэрээс 2014-2022 онуудад төв, орон нутагт 3 жилийн хугацаатай, хүүгүй олгосон зээлийн эргэн төлөлтөөс 6538 зээлдэгчтэй холбоотой, 15,505.9 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй үлдэгдэл байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Аж ахуйн нэгж байгууллагад эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн гэрээний 4.5-д "Олгосон санхүүжилтийг гэрээ байгуулсан өдрөөс хойш 36 сарын хугацаанд 100 хувь эргүүлэн төлнө", 4.6-д "Эргэн төлөлтийг гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэн хуваарийн дагуу сар бүрийн 25-ны дотор ХБХХЕГ-ын ХЭДС-ийн дансанд төвлөрүүлж, хариуцсан мэргэжилтэнд мэдэгдэж тооцоо нийлнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх онуудад санхүүгийн дэмжлэгийн эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлтийг хангуулаагүй, хугацаа хэтэрсэн, гэрээний үүргийн хангуулах ажлыг хангалтгүй зохион байгуулсан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

6. Анод банкны дамжуулан зээлдүүлэх гэрээгээр 800.0 сая төгрөг, Капитал банкны 3,865.1 сая төгрөг, Оёдлын нэгдсэн холбооны 13,388.7 сая төгрөгийн авлагуудын асуудлыг шийдвэрлүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"; Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэсэн заалтыг үндэслэн хариуцлага тооцуулахаар шийдвэрлэв.

Шийдвэрлэсэн нь: Он дамжсан авлагуудын асуудлыг шийдвэрлүүлэх талаар хэмжээ авч ажиллаагүй холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх

Зөвлөмж

1. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1.1 Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 20,837.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: ... 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх; ..." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх.

2. Хууль, тогтоомжтой холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх банк сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 2 дугаар хурлаар банканд байршуулсан 20,000.0 сая төгрөгийн эх үүсвэрт жилийн 4.4 хувиар хүү тооцож авахаар шийдвэрлэсэн байна. Жилийн хүүг тооцоолох суурь үзүүлэлтийг 2015-2020 онуудын инфляцын түвшний дундаж болон эрсдэлийн хувийг харьцуулсан гэх боловч тооцоолол хийсэн арга тодорхойгүй, 2021, 2022 оны үзүүлэлтийг авч үзэхгүй, хүүгийн түвшнийг тогтоох арга аргачлал, тооцоолол хийх маягт батлаагүй байна. Энэ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүртгэл, тайлангийн маягтын загварыг санхүү, төсвийн болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх зээлийн хүүг тогтоосон тооцоолол арга, аргачлалыг тодорхой болгож мөрдөх

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаатай холбоогүй дахин инженерчлэл хийх судалгаа шинжилгээний ажилд оролцсон хөдөө орон нутгийн ажилчдад 20.4 сая төгрөгийн дотоод томилолтын зардал зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн бусад хууль, тогтоомжтой холбоотой зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар нийт 7,912.4 сая төгрөгийн 39 алдаа¹ илэрснээс аудитын явцад тус алдааг залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
Засгийн газрын тусгай сан													
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	5	1,319,445.0			5	1,319,445.0	5	1,319,445.0				
Харьяа ХЭДСан													
2	Булган аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	3	92,402.7	1	85.0	2	92,317.7	3	92,402.7				
3	Дундговь аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	3	267,474.0	2	267,114.0	1	360.0	3	267,474.0				
4	Өмнөговь аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	274,690.8			1	274,690.8	1	274,690.8				
5	Төв аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	3	1,914,159.8		-	3	1,914,159.8	3	1,914,159.8				
6	Хэнтий аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	5,400.0	1	5,400.0			1	5,400.0				
7	Дархан-Уул аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	300.0			1	300.0	1	300.0				
8	Говь-сүмбэр аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	3,170.0			1	3,170.0	1	3,170.0				
9	Хан-Уул дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	726,497.0			2	726,497.0	2	726,497.0				
10	Баянгол дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	3	1,240,533.1	2	21,950.0	1	1,218,583.1	3	1,240,533.1				
11	Чингэлтэй дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	611,943.9			1	611,943.9	1	611,943.9				
12	Багахангай дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	11	1,311,543.9	5	588,393.9	6	723,150.0	11	1,311,543.9				
13	Сонгино хайрхан дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	49,532.0			1	49,532.0	1	49,532.0				
14	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институт	3	95,330.7			3	95,330.7	3	95,330.7				
Дүн		34	6,592,977.9	11	882,942.9	23	5,710,035.0	34	6,592,977.9				
Нийт дүн		39	7,912,422.9	11	882,942.9	28	7,029,480.0	39	7,912,422.9				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 46,263.1 сая төгрөгийн 84 зөрчил² илэрснээс, 53.2 сая төгрөгийн 8 төлбөрийн акт тогтоож, 4,759.4 сая төгрөгийн 25 албан шаардлага хүргүүлж, 25,944.5 сая төгрөгийн 49 зөвлөмж өгсөн. 15,506.0 сая төгрөгийн зөрчилд 2 хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засгийн газрын тусгай сан															
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	10	37,579,765.8	1	36,214.8	4	1,179,418.0	3	20,858,161.0	2	15,505,972.0				
Харьяа ХЭДСан															
2	Баян-өлгий аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	28,032.5			1	28,032.5								
3	Баянхонгор аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	-					1	-						
4	Говь-Алтай аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	31,708.6	1	1,025.0	1	30,683.6								
5	Дорноговь аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	-			1									
6	Дорнод аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	430,080.2			1	430,080.2								
7	Өмнөговь аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	248,520.0					1	248,520.0						
8	Сүхбаатар аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	3	47,503.5			2	46,423.5	1	1,080.0						
9	Сэлэнгэ аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	123,410.6					1	123,410.6						
10	Төв аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	61,584.8					1	61,584.8						

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

11	Ховд аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	3	3,050.0	1	500.0	1	2,550.0	1	-				
12	Хөвсгөл аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	272,741.0					1	272,741.0				
13	Хэнтий аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	6,500.0	1	6,500.0								
14	Дархан-Уул аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	5,570.0					2	5,570.0				
15	Орхон аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	3	113,458.0	2	824.0	1	112,634.0	-	-				
16	Говь-сүмбэр аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	4	2,153.1	1	169.1	0	-	3	1,984.0				
17	Хан-Уул дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	485,654.7				1	13,635.0	1	472,019.7			
18	Багануур дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	6	314,434.2				1	1,950.0	5	312,484.2			
19	Баянзүрх дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	3	1,284,735.4						3	1,284,735.4			
20	Налайх дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	3	118,990.4				1	18,095.6	2	100,894.8			
21	Баянгол дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	7	423,165.9						7	423,165.9			
22	Сүхбаатар дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	847,073.4				1	847,073.4					
23	Чингэлтэй дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	6	832,033.6	1	8,000.0				5	824,033.6			
24	Багахангай дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	92,475.0				1	92,475.0	1	-			
25	Сонгино хайрхан дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс	4	1,278,026.2				2	1,020,954.6	2	257,071.6			
26	Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	15,000.0						1	15,000.0			
27	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институт	8	33,515.7				3	8,032.1	5	25,483.6			
28	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	5	1,583,969.4				3	927,399.0	2	656,570.0			
Дүн		74	8,683,386.2	7	17,018.1	21	3,580,018.5	46	5,086,349.2				
Нийт дүн		84	46,263,152.0	8	53,232.9	25	4,759,436.5	49	25,944,510.2	2	15,505,972.0	-	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 8,827.0 сая төгрөгийн 13 зөрчил, илэрсэнээс 8,384.1 сая төгрөгийн 7 албан шаардлага хүргүүлж, 442.9 сая төгрөгийн 6 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэрс	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шилэн данстай холбоотой зөрчил													
1	Баян-өлгий аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	143,968.4			1	143,968.4						
2	Булган аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	534,305.1			1	534,305.1						
3	Дорноговь аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	3,802,651.7			1	3,802,651.7						
4	Дундговь аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	-			1	-						
5	Говь-сүмбэр аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	422,495.0			1	422,495.0						
6	Хан-Уул дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	308,701.3					1	308,701.3				
7	Налайх дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	-					1	-				
8	Багахангай дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	134,193.6					1	134,193.6				
9	Сонгино хайрхан дүүргийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	1,328,687.6			1	1,328,687.6						
10	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт үнэлгээ судалгааны институт	1	2,151,971.9			1	2,151,971.9						
	Дүн	10	8,826,974.6			7	8,384,079.7	3	442,894.9				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил													
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	-					1	-				
2	Сүхбаатар аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	-					1	-				

3	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	1	-				1	-			
	Дүн	3	-				3	-			
	Нийт дүн	13	8,826,974.6			7	8,384,079.7	6	442,894.9		